



175

**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2020 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/132

Ховд

**Ёс зүйн зөвлөл байгуулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ёс зүйн зөвлөлийн дарга: Н.Ганзориг - Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд: Д.Ариунбилэг - Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

С.Дорж - Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Мөнхжагаа - Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

П.Цэцэгсүрэн - Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр жилийн ажлын төлөвлөгөө гаргаж, ёс зүйн мэдээг хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллахыг Ёс зүйн зөвлөлийн дарга /Н.Ганзориг/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны А/93 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

2020-тг А/132 Чх  
00309